



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ**  
**ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 25 өдөр

Дугаар A/100

Улаанбаатар хот

Г Цанын Үндэсний шигшээ багийн  
бүрэлдэхүүнийг батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 11 дүгээр зүйлийн 11.3.7, 11.3.9, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны A/22 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цанын Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүний нэrsийг хавсралтаар баталсугай.

2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган тус хуулийн 8 дугаар зүйлд заагдсан нээлттэй мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллахыг Монголын цанын холбоонд үүрэг болгосугай.

3. Батлагдсан бүрэлдэхүүн, орон тооны дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр Монголын цанын холбоонд шилжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн агентлагийн ерөнхий нягтлан бодогч (А.Өнөрцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Цалин, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг улирал тутам хянаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Цэрэнболд)-т, холбооны саналыг үндэслэн бүрэлдэхүүн хөдөлгөөнд тухай бүр өөрчлөлт оруулахыг Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтэс (Э.Билэгт)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс (Н.Батсүх)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

О.БАТТУЛГА



142410285

Биеийн тамир, спортын улсын хорооны  
дэргүн 2024 оны 01 дугаар сарын 25.-  
ний өдрийн A/100 дугаар тушаалын  
хавсралт

ЦАНЫН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН 2024 ОНЫ БҮРЭЛДЭХҮҮН

№	Овог	Нэр	Албан тушаал	Төрөл
1	Дамбажамц	Баттулга	Дасгалжуулагч	Гүйлтийн цана
2	Мөнхөө	Шинэтэр	Дасгалжуулагч	Снөүборд
3	Сумьяасурэн	Тэмүүлэн	Дасгалжуулагч	Уулын цана
4	Батмөнх	Ачбадрах	Тамирчин	Гүйлтийн цана
5	Отгонлхагва	Золбаяр	Тамирчин	Гүйлтийн цана
6	Барсням	Номин-Эрдэнэ	Тамирчин	Гүйлтийн цана
7	Ариунсанаа	Энхтуул	Тамирчин	Гүйлтийн цана
8	Төрбат	Өсөх-Ирээдүй	Тамирчин (залуучууд)	Гүйлтийн цана
9	Ариунжаргал	Хүслэн	Тамирчин (залуучууд)	Гүйлтийн цана
10	Төмөр	Ариунболд	Тамирчин	Гүйлтийн цана
11	Ганбаатар	Ганзориг	Тамирчин	Снөүборд
12	Алтанзул	Ариунбат	Тамирчин (залуучууд)	Уулын цана
13	Эрдэнэчулун	Тэмүүлэн	Тамирчин	Уулын цана

---оо---